

Батлав: БОЖЯ-ны Хүрээлэн буй орчин,  
байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга

...../А.Энхбат/

Зөвшөөрч, хэргжүүлэх үүрэг хүлээсэн:  
“Бласт”ХХК-ний Гүйцэтгэх захирал

...../А.Тэмүүлин/



(Улаанбаатар хот,Налайх салбар)

**“БЛАСТ”ХХК-ИЙН “ТЭСРЭХ БОДИС ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН  
ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2688336



**ХЯНАСАН:**

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн: ...../

**Төлөвлөгөө гаргасан:**

“Налайх” салбарын дарга:...../Ц.Нямаа /

Байгаль орчны мэргэжилтэн:...../Д.Болортуяа /

2022 он

## Гарчиг

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
ТӨСЛИЙН НЭР:.....	3
Төслийн газар зүйн байрлал: .....	5
Төслийн тодорхойлолт, техник, технологи .....	6
Түүхий эдийн агуулах .....	9
Усан хангамж.....	10
Хог хаягдал .....	12
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	12
1.2. Төслийн хүчин чадал.....	14
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ГОЛ ЗОРИЛТ .....	15
ДӨРӨВ.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
1.1 Агаар.....	16
1.2 Хөрсөн орчинд.....	17
1.3 Усан орчинд .....	18
ТАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ .....	21
<b>1.</b> Осол эрсдэлийн менежмент .....	25
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ .....	26
7.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	30
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	31
АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	32
АРВАН ХОЁР .ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ .....	33
ХАВСРАЛТ .....	35

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**ТӨСЛИЙН НЭР:** “БЛАСТ” ХХК-ийн Налайх салбарын эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын төсөл

### ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, баганад мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “ хамааралгүй” гэж бөглөнө.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэг уурхайн нөхнө сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөж орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн	“Бласт” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011125047
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Тэсрэх материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, импортлох, худалдаалах
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Ландмарк 3 давхар
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Гүйцэтгэх захирал А.Тэмүүлин 99112528 temuulen@blastcompany.mn
	6. Төслийн даргын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Налайх дахь салбарын дарга Ц.Нямаа 99008940 nyamaa@blastcompany.mn
	7. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим хаяг:	Байгаль орчны мэргэжилтэн Д.Болортуяа 99293035 Bolortuya.d@blastcompany.mn
1.2	1. Төслийн нэр	Налайх дахь салбар (Энгийн болон эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах)
	2. Төслийн харьяаллын байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Баян уулын ар энгэр
	3. Төслийн ангилал	Үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2006.08.14
	5. Төсөл хэрэгжих хугацаа	Үйл ажиллагааны туршид тасралтгүй
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	2008.08.14 №13 Үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн акт Ажлын хэсгийн ахлагч ҮХЯ-ны ГУУХҮГ-ын орлогч дарга Б.Нэргүй
	7. ТЭЗҮ баталсан огноо	2019 он

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах.
- Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах баганад хавсралтын нэрийг оруулах.


д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
	Үйл ажиллагааны эрхлэх зөвшөөрөл  Дугаар Хүчинтэй хугацаа	Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, ажил үйлчилгээ хийх 864  2022 оны 12 сарын 23 өдөр
	Тусгай зөвшөөрлийн төрөл / химийн бодис ашиглах, тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу олгосон холбогдох зөвшөөрөл бусад баримт бичиг/  Дугаар Хүчинтэй хугацаа	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах  0002031  2021.12.31 – 2024.12.31
	Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт Галын дүгнэлтийн огноо, дугаар	2018 оны 04 сарын 06-ний өдөр №02-06-365/131  2022 оны 08 сарын 24 өдөр №2024699
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2017.10.30 №13/6532 БОЯ-ны Ерөнхий шинжээч Г.Нямдаваа
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2018 он БОНХЯ-ны ерөнхий шинжээч Г.Нямдаваа  2022 оны 09 сарын 14 өдөр
	Тухайн жилийн батлагдсан үйлдвэрлэлийн төлөвлөгөөний огноо	2016 оны 12 сарын 21 өдөр
	Газрын төлөв байдал чанарын хянан магадлагаа	2020 он

Төслийн газар зүйн байрлал:

Төслийн байршил. Налайх салбар нь нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт “Баян” уулын ар энгэрт Улаанбаатар хотоос зүүн урагш 45км, Налайх дүүргийн төвөөс урагш 10 км зайтай байршина. Үйлдвэрийн байгууламжийн байршлыг доорх зурагт тоймлон үзүүлэв.

Төслийн хэрэгжих орчмын байр зүйн солбицол:


X	Y
47° 44.164'X	107° 14.674'E
47° 44.122'X	107° 14.869'E
47° 43.992'X	107° 14.807'E
47° 44.036'X	107° 14.613'E



Төслийн орчны байршилын тойм зураг

Төслийн тодорхойлолт, техник, технологи

ТМ-ын үйлдвэр “Бласт” ХХК-ийн Налайх салбар нь жилд 7000 тонн усанд тэсвэртэй, савлагаатай эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтай. Усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодисыг 32, 38, 45, 70, 90, 110, 120, 140, 180, 200, 220 мм-ийн голчтой нийлэг олгойд ууталж, цаасан хайрцагт савладаг. Мөн хэрэглэгчийн хүссэн хэмжээ, голч бүхий эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэж, нийлүүлэх боломжтой.






*Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн барилга*



*Үйлдвэрийн аппарат, савлагааны хэсэг*

Налайх салбарын тэсрэх материалын агуулахын багтаамж 240 тн бөгөөд 4 агуулахыг бүгдийг нь тоосгоор барьсан. Агуулахуудыг ТАААНД-ийн шаардлагын дагуу тоногдсон бөгөөд 2, 2-оор нь бүлэглэж шороон далангаар тусгаарлан, зэлэн аянга зайлуулагчаар аянгаас хамгаалсан. Тэсрэх хэрэгслийг 1 дүгээр агуулахад хадгалдаг бөгөөд тэсрэх бодисыг 2, 3, 4 дүгээр агуулахуудад хадгалдаг.



Тэсрэх материалын агуулах №1



Тэсрэх материалын агуулах №2



Тэсрэх материалын агуулах №3



Тэсрэх материалын агуулах №4



### Түүхий эдийн агуулах

Налайх салбарын түүхий эд хадгалах агуулахуудын нийт багтаамж 1500 тн.



Түүхий эдийн агуулах (хашааны гадаа)



Хүчил хадгалах чингэлэг



Натрийн нитрит хадгалах чингэлэг

Зураг 1.1.7. Түүхий эд хадгалах чингэлэг

## Усан хангамж


Налайх салбарын усны хэрэгцээгээ 3 гүний худгаар хангадаг. Нэг дэх худаг (48 дугаартай худаг, 2005 онд “Эрдэнэ дрийлинг” ХХК өрөмдөж гаргасан, цооногийн ундарга 0.3 л/с, статик түвшин 60 метр, динамик түвшин 90 метр, насосны хүчин чадал 2тн/цаг) хашаан дотор усан сангийн доод давхарт байдаг. Хоёр дахь худаг (2007/07 дугаартай өрөмдмөл худаг, 2007 онд “Чемус” ХХК өрөмдөж гаргасан, цооногийн ундарга 0.2 л/с, статик түвшин 43 метр, динамик түвшин 108 метр) үйлдвэрийн урд хашааны гадна байрладаг. Гурав дахь худаг (2017/04 дугаартай худаг, 2017 онд “Эрдэнэ дрийлинг” ХХК өрөмдөж гаргасан, цооногийн ундарга 0.3 л/с, статик түвшин 45 метр, динамик түвшин 160 метр). Гүний худгаас 10 м<sup>3</sup> багтаамжтай ус нөөцлөх саванд усаа нөөцөлж хэрэглэдэг. Үйлдвэрийн усны эргэлтэд нийт 200 м<sup>3</sup> багтаамжтай усны сав ашигладаг. “Чандмань-Налайх” НӨҮГ -тай байгуулсан “Аж ахуйн нэгж байгууллагыг цэвэр усаар хангах бохир ус татан зайлуулах гэрээ”-ний дагуу авч ашигладаг.



Гүний худаг №1



Гүний худаг №2 Зураг



Гүний худаг №3 Зураг



1.1.14. Гүний худгууд



Үйлдвэрийн эргэлтийн усны сав, багтаамж - 200 м<sup>3</sup>  
м<sup>3</sup>



Ус нөөцлөх сав, багтаамж - 10

Зураг 1.1.15. Ус нөөцлөх сав

Эдгээр худгуудаас цэвэр усыг тус үйлдвэрийн “Чандмань-Налайх” НӨҮГ -тай байгуулсан “Аж ахуйн нэгж байгууллагыг цэвэр усаар хангах бохир ус татан зайлуулах гэрээ”-ний дагуу авч ашигладаг бөгөөд гэрээг жил бүр сунгадаг.

Зураг 1.1.18. Бохирын цэгүүд



Ахуйн усны бохирын цэг,  
багтаамж - 25 м<sup>3</sup>



Ажилчдын хоолны газрын  
бохирын цэг, багтаамж - 25 м<sup>3</sup>



Ахуйн усны бохирын цэг,  
багтаамж - 25 м<sup>3</sup>

### Хог хаягдал

Уурын зуухны үнс болон ахуйн хог хаягдлыг хогийн цэгээс хог тээвэрлэх машинаар тээвэрлэн Налайх дүүргийн хогийн цэгт зайлуулдаг. Хог хаягдлыг тус байгууллагын “Тохижилт үйлчилгээ” НӨҮГ -тай байгуулсан “Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээний дагуу нутаг дэвсгэрээс зайлуулдаг. Уурын зуух 2022 онд хаасантай холбоотой үнс гарахгүй болсон.



*Хог хаягдал түр хадгалах цэг*

Ахуйн болон үйлдвэрийн бохир усыг тус тусын бохирын цэгт хураан бохир ус тээвэрлэх машинаар тээвэрлэн тус үйлдвэрийн “Чандмань-Налайх” НӨҮГ -тай байгуулсан “Аж ахуйн нэгж байгууллагыг цэвэр усаар хангах бохир ус татан зайлуулах гэрээ”-ний дагуу Налайх дүүргээс зөвшөөрөгдсөн бохирын цэгт асгадаг

Хог хаягдлыг Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ -тай гэрээ хийж хог хаягдлыг ачуулна.

Зураг 1.1.19. Бохир ус тээвэрлэж асгах машин




## ХОЁР.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Технологи.

Үйлдвэрийн технологийн ерөнхий зарчим нь усан фазын уусмалыг тосон фазын уусмалтай молекулын түвшинд нэгтгэж, үүн дээрээ тусгайлан бэлдсэн хөөсрүүлэгч бодисыг нэмж усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэн гаргахад оршино. Үйлдвэрийн үйл ажиллагаа нь бүрэн механикжсан, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны удирдлага хяналтын тогтолцоо автоматчилагдсан, компьютерын удирдлагын системтэй. Усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрлэлийн технологи нь дараах үндсэн 7 үе шатаас бүрдэнэ. Үүнд:

1. Түүхий эдийг бутлах, уусган хайлуулах, бэлдэх
2. Уусмалуудыг тээвэрлэх
3. Эмульсжүүлэх
4. Эмульсийг хөргөх
5. Хийжүүлэгч бодис нэмэх
6. Холих, жигдрүүлэх
7. Бэлэн болсон бүтээгдэхүүн савлах

ТМ-ын үйлдвэрийн технологийн ерөнхий схем



Тус үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмжүүд нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

- Бутлагч төхөөрөмж
- Усан фазын уусмал бэлтгэх сав
- Тосон фазын уусмал бэлтгэх сав
- Шүүлтүүр болон бэлэн болсон уусмалуудыг хадгалах сав руу өгөх шугам
- Усан фазын уусмал хадгалах сав
- Тосон фазын уусмал хадгалах сав
- Усан фазын уусмал тээвэрлэх насос
- Тосон фазын уусмал тээвэрлэх насос
- Шүүлтүүр ба уусмалын урсгал хэмжигч
- Хүчтэй эмульсжүүлэгч машин
- Хөргөлтийн туузан дамжлага
- Хийжүүлэгч бодис бэлтгэх-тэжээлийн сав
- Хийжүүлэгч бодис тээвэрлэх насос
- Холигч хүрд
- Савлах туузан дамжлага
- Савлагч машин

Үйлдвэрийн технологи үйл ажиллагаа нь 4.0МПа даралттай нойтон уураар тэжээгдэн явагдах ба үүнийг өөрийн уурын зуухаар хангана.

## 1.2. Төслийн хүчин чадал

Налайх дахь эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор одоогийн байдлаар нь 50 ажилчин, албан хаагчтай ба 1 ээлжээр ажиллахад жилд 9000 тонн савлагаатай эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай. Тэсрэх материалын агуулахын багтаамж 240 тн. 2010 онд 1500 тн багтаамжтай түүхий эдийн агуулах барьсан 2012 онд үйлдвэрийн шугамыг орчин үеийн бүрэн автоматчилагдсан аюулгүй ажиллагааг бүрэн хангасан, технологийн шугамыг нэвтрүүлсэн 2013 онд Тэсрэх бодисын сорилт судалгааны итгэмжлэгдсэн төв лаборатори байгуулсан.

## ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ГОЛ ЗОРИЛТ

### 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

#### 3.1.1 Агаар орчмын бохирдолт

- Нөлөөллийн код-Агаар  
Уурын зуухны утаа, үнс  
Дизель түлшний ууршилт  
Тээвэрлэлтийн утаа, тоосжилт
- Нөлөөлөлд орох объект  
Цогцолборын ойр орчимд байгаа хүн амьтан  
Цогцолборын ажиллагсад  
Хөрс  
Ургамал

#### 3.1.2 Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ, байгаль орчны зөвшөөрөл

Гэрчилгээгээр зөвшөөрөгдөх хэмжээ.

Агаар бохирдуулагч бодисын хүрэлцэх хэмжээ

MNS5885:2008

Агаар бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээ

MNS4585:2007

#### 3.1.3 Ажиглалт хяналт явуулах шаардлага

- Ашиглалтын хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц, дээж авах болон шинжилгээ хийлгэж зөвлөгөө авч байх.
- Ашиглалтын хугацаанд ажилчдын эрүүл мэндийг мэргэжлийн эмч нарт үзүүлж мэргэжлээс шалтгаалах өвчнүүдийг эмчийн хяналтанд авч байх.
- Аюулгүй ажиллагааны дүрэм журмын хэрэгжилтийг хянаж байх.

#### 3.1.4 Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр

“Бласт” ХХК-ний үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тусгаж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж байх.

## ДӨРӨВ.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажиглалт хяналт явуулах шаардлага

- Төслийн хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаар, хөрс, усны сорьц, дээж авах болон шинжилгээ хийлгэж зөвлөгөө авч байх
- Төслийн хугацаанд ажилчдын эрүүл мэндийг мэргэжлийн эмч нарт үзүүлж мэргэжлээс шалтгаалах өвчнүүдийг эмчийн хяналтад авч байх
- Аюулгүй ажиллагааны дүрэм журмын хэрэгжилтийг хянаж байх

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /Хэмжих нэгж/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1.1 Агаар							
1	Ажилчдын эрүүл мэндэд сэргөөр нөлөөлөх	Ажлын байрны тоосжилтыг хэмжих, тоосны шинжилгээ өгөх	Цогцолборын хэмжээнд	Үйл ажиллагааны турш	0.3	2023 онд	“Агаарын тухай” хууль МНЭ 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
2	Машин техникийн яндгаар агаарын бохирдол үүсгэх	Салбарын нийт машинд цаг тухай бүрд нь хяналт тавин үйлчилгээ хийх	Салбарын машинуудад	Үйл ажиллагааны турш	-	2023 онд	
3	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх	Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийг галын хор, аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох.	Салбарын машинуудад	Үйл ажиллагааны турш	-	2023 онд	

*Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*



№	Г ол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх хэлбэр	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1.2 Хөрсөн орчинд							
1	Хөрсөнд химийн бодис шингэж хөрс боихрдуулах	АХХ хадгалах цэгийг бетонон суурь цутгах	Салбарт	1	Үйл ажиллагааны зардлаас	2023 онд	МNо 5850:2008. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Төслийн орчин болон нийтийн зам дагуу тээврийн хэрэгслийн байнгын хөдөлгөөний улмаас хог хаягдал ил задгай хаягдаж хөрс бохирдох	Тогтмол хувиар гарган цэвэрлэх	Цогцолборын ойр орчим	тогтмол	Үйл ажиллагааны зардлаас	2023 онд	
3	Хөрс бохирдохоос сэргийлэх	Хөрсний шинжилгээ өгөх	Цогцолборын ойр орчим	1	0,3	Жилд/1 удаа	
4	Төслийн орчин болон нийтийн зам дагуу тээврийн хэрэгслийн байнгын хөдөлгөөний улмаас хог хаягдал ил задгай хаягдаж хөрс бохирдох	Хог хаягдлын цэгийн гадаргын Усанд автахааргүй байрлалд байгуулах,салхины голлох чиглэлээс хаасан хаалт хийх, хогийн цэгт тогтмол ариутгал хийх хур хог үүсгэхгүй зайлуулах	Цогцолборын ойр орчим	тогтмол	Үйл ажиллагааны зардлаас	2023 онд	

Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Г ол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1.3 Усан орчинд							
1	Гүний ус болон унд ахуйн цэвэршүүлсэн ус бохирдох	Хими бактерлогийн шинжилгээ хийлгэх	Цогцолборын худаг	1	0,3	Жилд/4	Ундны ус, эрүүл ахуйн шаардлага МН8 900:2010
2	Зөвшөөрөлгүй ус ашиглах	Ус ашиглахтай холбоотой бичиг баримтийн хугацааг сунгуулах	Цогцолборын худаг	1	0,05	2023 Онд Жилд/1	
3	Хаягдал усны шинжилгээ өгөх	Хаягдал усны дүгнэлт гаргуулж шинжилгээ өгч ажиллах	Цогцолборын бохирын худаг	1	0.01	2023 Онд Жилд/1	
4	Зөвшөөрөлгүй ус ашиглах	Худгийн тоолуур баталгаажуулалт хийх	Цогцолборын худаг	1	0,05	2023 Онд Жилд/1	

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

## ТАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлт хийх шаардлагагүй

Тайлбар: Газар шорооны ажил хийгдээгүй. Олборлолт явуулдаггүй болно.

“БЛАСТ” ХХК 2022 онд Налайх дүүргийн мод үржүүлгийн газар 200 ширхэг мод тарихаар төлөвлөсөн.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцах эзэн
1	/Дүүргийн мод үржүүлгийн газар 200 ш мод тарих/	Жил бүр	500.0	Салбарын нийт ажилчид
	Дүн		500.0	

## ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговор олгохгүй.

Тайлбар: Салбарын аюулгүйн бүст хүн ам суурьшсан төв байхгүй.

## ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс байхгүй байна.

Түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгааг (эртний хүмүүсийн үлдээсэн тодорхой орон зай, цаг хугацааг төлөөлж чадах дурсгалыг) зөвхөн газрын хөрсөн дээр илэрхий мэдэгдэх дурсгалт зүйл дээр тулгуурлан хийдэг.

Энэхүү төсөл хэрэгжүүлэх явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хирэгсүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож хамгаалалт гарган зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хамгаалалтад авах шаардлагатай. Эдгээрийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.

Үндсэн гүйцэтгэгч албан тушаалтнуудад тухайн бүс нутгийн түүхэн дурсгалт нөөцийн ач холбогдол, археологийн олдворын талаарх хууль зүйн мэдлэг, хариуцлагын талаар сургалтын хөтөлбөр дээр танилцуулсан байх ёстой. Төсөл хэрэгжүүлэгч нь археологи, түүх соёлын дурсгалтай зүйлийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний талаар ажлын талбай

дээр ажилчдад танилцуулж уг төлөвлөгөөний хуулбарыг лавлаж үзэхэд туслах зорилгоор ил бэлэн байлгах ёстой.

“Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн гуравдугаар бүлгийн 12, 13-р зүйлд заасны дагуу газрын хэвлийг ашиглах явцад археологийн олдвор болон түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл гүйцэтгэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Түүх соёлын үлэм хөдлөх дурсгалт зүйлийг шинжлэх ухаан болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөхийг хориглоно гэсэн заалтыг мөрдлөг болгоно.

Цогцолборыг байгуулах ажлын явцад урьд өмнө үл мэдэгдэж байсан археологийн олдвор эсвэл түүх соёлын дурсгалт зүйлийг нээсэн тохиолдолд тус газрыг шалгаж үзтэл түүний ойр хавьд ямар ч төрлийн үйл ажиллагаа явуулж болохгүй.

Нээлт хийсэн газрыг тод харагдахаар заан тэмдэглэж зөвшөөрөл авсан төслийн талбайн бусад хэсэгт үйл ажиллагаа явуулахгүй хязгаарлана. Уг түүхэн дурсгалт зүйл буюу түүнтэй холбоотой зүйлийг уг түүхэн дурсгалт зүйлийн бүрэн бүтэн байдал устгах аюул учраагүй бол зөөх буюу зайлуулахыг хориглоно. Хэсгийн дарга нь олдсон зүйлтэй холбогдуулан төв орон нутгийн засаг захиргаа, боловсрол шинжлэх ухаан, соёлын яаманд илгээж холбогдох шаардлагыг хангах үүрэгтэй. Үүнд:

- Олдсон түүхэн дурсгалт зүйлийн мөн чанар, ерөнхий шинж
- Тодорхой тайлбар, газрын зураг дээрх байршлын солбицол болон нээж илрүүлсэн цаг хугацаа
- Энэхүү түүхэн дурсгалт зүйлийг олоход явуулж байсан үйл ажиллагааны тухай тайлбар /2022 онд манай байгууллага нь Улаанбаатар их сургуультай хамтран “Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5,27-р дугаар зүйлийн 8-г заасны дагуу 2022 оны 4 сард 0202685 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газарт судалгааны ажил хийж гүйцэтгэсэн. Тайланд дурдаж дүгнэлт хийснээр эртний шим ертөнцийн олдвор илгээгүй тул тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахад татгалзах зүйлгүй гэж гарсан.

## НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ

Химийн аюулын төрөл, шинж чанар

Эцсийн бүтээгдэхүүн нь мөсөн шүү боловсруулах үйлдвэрийн химийн бодисууд учир төсөлд химийн бодисын эрсдэлийн үнэлгээг хийх шаардлагатай. Учир нь сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд урьд өмнө нь хүний бие, хүрээлэн буй орчинд нөлөөгүй, эсвэл аюулгүй гэж тооцогдож байсан хэд хэдэн бодисууд хорт хавдар үүсгэх, эсвэл хүний нөхөн үржихүйд хортой болох нь нотлогдоод байна. Мөн хор аюул нь мэдэгдэж буй бодисыг удаан хугацаанд ашиглахад орчин, ажиллагсдын эрүүл мэндэд үл мэдэгдэм тунгаар нөлөөлсөөр байдаг байна.

Химийн хортой ба аюултай бодисуудаас хүн ам, түүний дотор тухайн бодистой өдөр тутам харьцан ажилладаг ажиллагсдын эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд нөлөөлөх аюулыг дараах бүлгүүдэд хувааж болох юм.

- Хурц нөлөөлөл. Зөвхөн нэг удаагийн тархалтаас илрэх бодис хэвийн хэмжээнээс хэтэрч тархсанаас амьсгал боогдох, ухаан алдах, түлэгдэх, бэртэлт авах, үхэлд хүрэх зэрэг аюултайг харуулна.
- Архаг нөлөөлөл. Хорт бодис удаан хугацааны туршид олон удаагийн давтамжтай тархсаны дүнд илрэх нөлөөлөл орно.
- Хэсгийн нөлөөлөл. Хорт бодис хүрсэн биеийн хэсэгт илрэх нөлөөлөл юм.
- Системчилсэн нөлөөлөл. Хорт бодис биед шингэн орсон хэсгээс өөр хэсгүүдэд нөлөөлөл нь тархах илрэлийг хэлнэ.
- Түр нөлөөлөл. Хорт бодисын нөлөөллөөс хүний биеийн эд эс ангижрахад нөхөн сэргэж хэвийн байдалдаа орно.

Хорт нөлөөлөлд өртсөний дараа нөхөн сэргэлт буюу эдгэрэлт явагдах нөхцөл боломжгүй (эргэлт буцалтгүй) болохоор бол байнгын нөлөөлөлд хамруулна. Гэхдээ хүний эрүүл мэндэд нөлөөлөх эдгээр аюулын ангиллын нэр томъёог (химийн бодис уусмал тус бүр дээр) ихэнх тохиолдолд зөв хамтатган хэрэглэх нь аюулын нөлөөллийг оновчтой тодорхойлох боломжийг олгодог байна. Тухайлбал химийн уусмалд арьс түлэгдэх нь хурц, хэсгийн, түр нөлөөлөл гэж тодорхойлогдож байхад уушгины хавдар нь архаг, системчилсэн, байнгын нөлөөлөл гэж тодорхойлогдоно. Гэхдээ тухайн үеийн эрсдэлийн үнэлгээгээр архаг

ангилалд хамрагдаж байсан нөлөөлөл нь хожим хурц нөлөөлөлд, эсвэл нөхөн үржихүйн хувьд үр удамд хортой нөлөөлөлд шилжиж болно.

### Хорын аюул

Хорын аюултай бодисуудыг онцгой, их, дунд, бага гэж ангилна. Хэрэв бодисуудын холимог байвал аюулыг үнэлэхдээ онцгой аюултай гэсэн ангилалд хамааруулна. Мөн хор хөнөөл нь тодорхойгүй бодисыг үнэлэхдээ хоргүй гэж үзэх тодорхой үндэслэл байхгүй л бол их хортой гэсэн ангилалд оруулна.

- “Онцгой аюултай” ангилалд хорт хавдар үүсгэдэг, үр удамд нөлөөлөх болон нөхөн үржихүйд хор хөнөөл учруулах бодисууд багтах ба хор, бордоонд энэ ангиллын химийн бодис байхгүй байна
- “Их аюултай” ангилалд их хортой, хортой, түлдэг, арьс цочроогч бодисууд багтана.
- “Дунд зэргийн аюултай” гэсэн ангилалд амьсгалын замаар дамжиж нөлөөлөх бодисууд хамаарна.

Дээрх 3 ангиллын аль ч ангилалд ордоггүй бодисуудын “бага аюултай” гэсэн ангилалд хамааруулна.

### Физик-химийн аюул

Химийн бодисын физик-химийн үндсэн аюул нь шатах, тэсрэх, исэлдэх чанар бөгөөд эдгээр шинж чанарыг тодруулан авч үзвэл шатамхай чанар нь гол төлөв аюулгүй ажиллагааны асуудалтай шууд холбоотой гардаг. Шингэн бодисын хувьд шатамхай чанар нь “шаталтын цэг”-тэй урвуу хамааралтай, өөрөөр хэлбэл шаталтын цэг багатай шингэн бодис хамгийн аюултай байхад өндөртэй нь аюул багатай байдаг байна. Химийн бодисын физик-химийн дээр дурдсан 3 шинж чанар бүхий аюулыг

- туйлын шатамхай
- маш их шатамхай
- шатамхай
- тэсрэмтгий
- исэлдэмтгий гэж 5 ангилна.

## Тун-хариу үйлчлэл, тун нөлөөллийн харьцаа

Аливаа бодисын аюулыг тогтоосны дараа түүний хэмжээ, цар хүрээг тооцоолох, өөрөөр хэлбэл концентрацийн ямар түвшинд аюултай болон хортой нөлөөлөл бий болохыг тогтоох шаардлагатай. Үүнийг гал түймэр, эсвэл тэсрэлтээс үүдэн гарах хор хөнөөлийн хувьд тооцоолоход харьцангуй хялбар байдаг бол химийн хорт бодис хүнд хэрхэн нөлөөлж болохыг тогтооход маш хүнд байдаг. Ялангуяа шинэ тутам байгуулагдсан үйлдвэр, лабораторийн хувьд тэнд ажиллагсдын талаарх болон орчны хяналт шинжилгээ, хүн амын эрүүл ахуйн эмнэлгийн үзлэгийн дүн, дүгнэлт гараагүй нөхцөлд дүгнэлт хийх боломжгүй байдаг. Иймд цементийн үйлдвэрт хэрэглэгдэх химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, түүний дотор тун-хариу үйлчлэл, тун нөлөөллийн харьцааг тодорхойлох боломж нь энэ удаагийн байгаль орчны нарийвчилсан болон химийн бодисын эрсдэлийн үнэлгээний хүрээнд хязгаарлагдмал байна. Харин 2017 оноос хийгдэх БОНБНҮнэлгээний нэмэлт тодотголын үед энэ харьцааг нарийвчлан тогтоох, химийн бодисын эрсдэлийн үнэлгээг иж бүрэн хийх боломжтой болох юм гэж үзэж байна.

## Босго ба босго бус нөлөөлөл

Эрсдэлийн үнэлгээ хийхэд босго нөлөөлөл буюу босго концентраци (хүний организмд нэвтрэн орж болох хамгийн бага хэмжээ буюу тухайн хэмжээгээр нэвтэрсэн тохиолдолд ажиллах чадвараа алдах, толгой эргэх, бие эвгүйтэх нь мэдэгдэнэ), босго бус нөлөөллийг химийн бодис бүр дээр тогтоож өгөх шаардлагатай байдаг. Босго нөлөөлөл нь бодисын босго концентраци ба өртөлтийн хязгаар (ПДК)-аар тодорхойлогдоно. Энэ нь 8 цагийн ажилтай хүмүүсийг удаан хугацаанд нэг байранд ажиллахад өвчлүүлэх хэмжээнд хүргэдэг бодисын концентраци юм. Мэргэжлээс шалтгаалах өртөлтийн түвшинг үнэлэх судалгааны материал тус системд ажиллах хүмүүсийн хувьд одоогоор байхгүй учир тогтоох боломжгүй байна.

## Мэргэжлээс шалтгаалах өртөлт

Ажлын байран дахь хамгийн нийтлэг өртөлтийн замуудад амьсгалын замаар ба арьсаар өртөх өртөлт орно. Ажлын байрны эрүүл ахуйн хяналт сайн, мэргэжлийн мэргэшсэн ажилтан ажиллаж буй нөхцөлд амаар буюу залгих замаар химийн бодисын нөлөөлөлд өртөх асуудал бараг гардаггүй.

Иймд мэргэжлээс шалтгаалах өртөлтөд үнэлгээ хийхэд хорт бодисын тархалтад өртөж болох хүний тоо, өртөлтийн байж болох эрчим, давтамж, үргэлжлэх хугацаа, нөлөөллийн аюулыг арилгах, бууруулах, зорилгоор хэрэглэж болох хувийн хамгаалалтын хэрэгсэл ба хяналтын аргууд зэргийг нарийн мэдсэн байх шаардлагатай. Эдгээрт хариу өгсөний үндсэн дээр тохиолдож болох “хамгийн хүнд” нөхцөлийг тодруулах боломж олдоно. Тохиолдож болзошгүй аюулыг хянах, өөрөөр хэлбэл өртөлтийн ерөнхий байдлыг тандах зорилгоор аюул гарч болзошгүй газруудад хяналтын хэмжилт, дээж судалгааны аргыг орчны хяналт шинжилгээний хөндлөнгийн байгууллагаар заавал хийлгэж, зохих дүгнэлтийг тухай бүр гаргуулж байх шаардлагатай.

Тэсрэх материалын үйлдвэрийн химийн бодисын эрсдэлийн үнэлгээ

Тэсрэх материалын үйлдвэрт хэрэглэгддэг химийн бодисуудын эрсдэлийн үнэлгээг үйлдвэрийн ажиллагсдыг химийн хортой бодисын нөлөөлөлд их бага хэмжээгээр өртөхөөс урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хор аюулыг бууруулах ямар арга хэмжээ авч болохыг тодруулах зорилго тавив. Бодисуудын физик, химийн болон бусад шинж чанар, хор аюулын ангилал, ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээ, учруулах аюул, хордлогын шинж, түүнээс урьдчилан сэргийлэх, аюулыг арилгах арга хэмжээ, бодисыг тээвэрлэх, хадгалах, саармагжуулах, ашиглах хамгаалах хэрэгсэл, анхны тусламж үзүүлэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын талаар авч үзсэн болно.



	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж	Баримтлах хууль, журам, стандарт
<b>б.Осол эрсдэлийн менежмент</b>							
6.1	Хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулах	Химийн бодисын агуулахад тогтмол хяналт тавих	Салбарын нийт бодисын агуулахад	Үйл ажиллагааны турш	-	Үйл ажиллагааны турш	Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт шинжилгээ MNS 5080:2001 стандарт
6.2	Мэдээлэл дутагдсанаас осол аварг өртөх	Байгаль орчныг хамгаалах сургалт ажилдад орох	Нийт ажилчид	Улиралд 1 удаа	-	Үйл ажиллагааны турш	
6.3	Галын осол аваараас урьдчилан сэргийлэх	Ажлийн байрны галын аюулгүйн дүгнэлт гаргуулах	Тэсрэх бодисын агуулах, энгийн тэсрэх бодисын үйлдвэрт	2 жилд 1 удаа	0,4	2023 онд	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн
6.4		Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажилчид	1 жилд 1 удаа	-	2023 онд	- Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, журмыг баримтлах

*Осол эрсдэлийн менежмент*

## ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Технологийн гаралтай хог хаягдал

Төслийн үйл ажиллагаас дараах төрлийн технологийн гаралтай хог хаягдал гарна. Үүнд:

- Түүхий эдийн шуудай
- Тэсрэх хэрэгслийн цаасан хайрцаг
- Техникийн тосны хоосон төмөр торх (бочка)
- Тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, тосолгооны бүтээгдэхүүний хаягдал
- Автомашины шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн хаягдал

Үндсэн түүхий эдийн сав баглаа боодол болох аюултай хог хаягдлыг “Цэцүүх трейд” ХХК- д гэрээгээр нийлүүлдэг.

Аюултай хог хаягдал нийлүүлэх хууль дүрэм журмын дагуу аюултай хог хаягдлыг нийлүүлдэг.

Химийн бодисын хог хаягдлыг аюулгүй устгаж байх юм. Химийн хорт бодисын хаягдлыг устгахад “Химийн хорт бодисоос хамгаалах тухай” хуулийн 11, “Химийн хорт бодисын хадгалалт, хамгаалалт, хамгаалалт, тээвэрлэлт, устгалын тухай журам”-ын 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2002 оны 135 дугаар тогтоолын хавсралт “Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам” - ыг мөрдөнө.

Саармагжуулах, хоргүйжүүлэх судалгаа

Натрийн нитрит (NN01)

Бодис дээр карбонат натри ба усыг 1:1 харьцаагаар хийнэ. Дээр нь 6М давсны хүчлийн уусмал нэмж саармагжуулсны дараа уусмалын орчныг рН-6.0-9.0 болтол усаар шингэрүүлж бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаяна.

Азотын хүчил (^N03)

Кальцийн, натрийн гидроксид болон натрийн карбонатын (техникийн сод) 10-20%-ийн уусмалаар саармагжуулна. Азотын хүчлийг саармагжуулагч бодистой хольж 10 цаг орчим байлгана. Саармагжуулсны дараа уусмалын орчныг рН-6.5-8.0 болтол усаар шингэрүүлж, бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаяна.

Химийн хорт бодисын хаягдлыг устгах аргыг дараах байдлаар ангилна. Үүнд:

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Бласт” ХХК-ийн Налайх салбарын  
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Булах
- Шатаах
- Физик, химийн аргаар боловсруулах
- Ууршуулах
- Бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаях

Булах арга

- Химийн хорт бодисын хаягдлыг төрөлжүүлэн ялгаж, экологийн шаардлагын дагуу аюулгүй байдлыг хангасан нөхцөлд тусгай цэгт булах
- Хор, аюулын зэргээс нь хамаарч хяналтын дор аюулгүй байдлыг хангах хатуу хог хаягдалтай хамт булах
- Шатамхай шингэн, исэлдүүлэгч, цохилт доргилтод тэсрэх, хурц үнэртэй, ус хүчил шүлттэй урвалд орж хортой нэгдэл үүсгэх шинж чанартай бодисыг булах аргаар устгаж болохгүй

Шатаах арга

- Хортой хаягдлыг шатаахдаа цаг агаар, улирлын байдал, салхины чиглэлийг харгалзан хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, байгаль орчинд хор нөлөөгүй байх нөхцөлийг хангасан байх
- Химийн хорт бодисын хаягдлыг шатаахдаа агаарт аль болох ууршуулахгүй байх
- Шатамхай шингэн, хүнд металл, тэсрэх бодис болон шаталтын үр дүнд хортой аюултай бодис ялгаруулах химийн нэгдлийг энэ аргаар устгаж болохгүй

Физик, химийн аргаар боловсруулах

- Химийн аргыг хэрэглэх үед их хэмжээний үлдэгдэл үүсэх эсэхэд анхаарах
- Концентрацитай хүчил, шүлтийг хэрэглэж хаягдлыг саармагжуулах, хоргүйжүүлэх үйл ажиллагааг явуулахад их хэмжээний дулаан, хортой хий, утаа болон шингэн ялгардаг учир онцгой анхаарах
- Онцгой хортой, тэсрэмтгий, дулаан их ялгаруулдаг бодисуудыг энэ аргаар устгаж болохгүй

Ууршуулах арга

- Энэ аргаар устгал хийхдээ хүн ам оршин суудаг газраас хол зайтай, халуун, салхитай өдрийг сонгоно

- Бага хэмжээтэй, түргэн ууршдаг, харьцангуй бага хортой, озоны давхаргад нөлөөлдөггүй хаягдлыг агаарт шууд ууршуулж болно
- Амьсгалахад их хортой, хялбар болон өөрөө шатдаг, агаарт тэсрэлт үүсгэдэг, муухай үнэртэй, уурших биш эсвэл бага зэрэг уурших бодисуудын хаягдлыг энэ аргаар устгахгүй.

#### Бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаях арга

- Биологийн задралд хялбар орох, бага хэмжээний органик бодисуудын хаягдлыг бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд хаяж болно
- Органик бус бодисын хаягдлыг энэ аргаар устгахдаа урьдчилан саармагжуулна
- Хялбар шатамхай, усанд уусдаггүй, биологийн задралд ордоггүй, бохир усны системд нөлөөтэй, зэврэлт үүсгэдэггүй, устай холилдохоороо хортой хий ялгаруулдаг бодисуудын хаягдлыг энэ аргаар устгахгүй

#### Удаан хугацаагаар хадгалах арга

- Химийн хорт бодисын хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүйгээр устгах техник, технологи, санхүүгийн асуудал шийдэх хүртэл тусгай зориулалтын агуулахад хадгалах
- Хорт бодисын хаягдлын нэр төрөл, хэмжээг тодорхойлсон байх
- Хорт бодисын хаягдлын нэр төрөл, хэмжээг тодорхойлсон байх
- Хорт бодисын хаягдлыг устгах эрсдэлийн үнэлгээ хийлгэх
- Устгал хийхэд шаардлагатай материалыг урьдчилан бэлтгэх
- Хорт бодисын хаягдлыг холбогдох эрх бүхий байгууллагын хяналтын байцаагчийн хяналт доор зөвшөөрөгдсөн устгалын цэгт устгах
- Устгах хортой хаягдлын шинж чанар, устгах аргаас хамаарч ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгслийг бэлтгэх, хэрэглэх
- Химийн хорт бодисын хаягдлыг шинж чанар, онцлогоос нь хамааруулж төрөлжүүлэн ангилж, аюулгүй нөхцөлийг хангасан сав, баглаа боодолд хийж, шаардлагатай шошго, тэмдэглэгээ хийх
- Хорт бодисын хаягдлыг шинж чанар, онцлогоос нь хамааруулж төрөлжүүлэн ангилж, аюулгүй нөхцөлийг хангасан сав, баглаа боодолд хийж, шаардлагатай шошго, тэмдэглэгээ хийх
- Хорт бодисын хаягдлыг тээвэрлэх зам / маршрут/-ыг тогтоосон байх
- Хорт бодисын хаягдал түр хадгалах байр нь орчиндоо сөрөг нөлөө үзүүлэхгүй, бусдад ашиглагдахгүй байх нөхцөлийг хангасан байх

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Бласт” ХХК-ийн Налайх салбарын  
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Хорт бодисын хаягдлыг зөвхөн дангаар тээвэрлэх ба тээврийн хэрэгсэл нь сэрэмжлүүлэх тэмдэгтэй байх
- Хорт бодисын хаягдлыг зөвхөн дангаар тээвэрлэх ба тээврийн хэрэгсэл нь сэрэмжлүүлэх тэмдэгтэй байх
- Хорт бодисын хаягдал устгах цэгийн орчинд хамгаалалтын бүс тогтоох
- Хорт бодисын хаягдлыг устгасан тухай тэмдэглэл хөтлөх
- Хаягдлыг ямар аргаар яаж устгал хийсэн тухай тэмдэглэл хөтлөх

№	Г ол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
<b>7.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө</b>							
7.1	Хүрээлэн буй орчин бохирдох	Хог хаягдлын гэрээ байгуулах	Цогцолборын хэмжээнд	1	-	Тайлант онд	Хог хаягдлын тухай хууль - 9.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж 20 дүгээр зүйл .1 - Хог хаягдал хаях 11 дүгээр зүйл .1.2  Стандарт - Ахуйн хог хаягдал. Тээвэрлэлт,
7.2	Хадгалах, хогийн савны хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх	Дахивар хог ангилан ялгаж гэрээт байгууллагад нийлүүлэх		1	-	Тайлант онд	
7.3	Аюултай хогийг зориулалтын бус газар устгаснаас байгаль орчинд сөрөг нөлөө үүсэх	Аюултай хог хаягдлын гэрээ байгуулах		1	-	Тайлант онд	
7.4	Хог хаягдал салхинд хийсэх, хөрсөнд нэвчилт үүсгэх	Ангилан ялгалтын хог хаягдлын цэг шинээр байгуулах		1	Үйл ажиллагааны зардлаас	Тайлант онд	
7.5		Хатуу болон шингэн хаягдлын цэг, түүний орчимд тогтмол ариутгал хийх		1	Үйл ажиллагааны зардлаас	Тайлант онд	

*Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг “Бласт” ХХК -ийн удирдлага хүлээнэ.

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /мян.төг/	Хариуцах эзэн
8.1	Аюултай хог хаягдал нийлүүлсний төлбөр төлөх	Гэрээний дагуу төлбөрийг төлөх	Улирал/1	Үйлдвэрийн зардлаас	Салбарын нягтлан
8.2	Ус ашигласны төлбөр	Төсвийн дансанд төвлөрүүлэх	Улирал/1	Үйлдвэрийн зардлаас	Салбарын нягтлан
8.3	Хог хаягдал нийлүүлэх гэрээний дагуу төлбөр төлөх	Гэрээнд заасан дансанд төвлөрүүлэх	Улирал/4	Үйлдвэрийн зардлаас	Салбарын нягтлан
8.4	Дүүргийн байгаль орчны хяналтын байцаагчтай байнгын ажил төрлийн холбоотой байх	-	Жилд/1	Үйлдвэрийн зардлаас	Салбарын ХАБ
8.5	Газар ашиглалтийн төлбөрийг дүүргийн төсвийн дансанд оруулах	Төсвийн дансанд төвлөрүүлэх	Үйлдвэрийн зардлаас	Ня-бо	Салбарын нягтлан

## АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2018 онд “Газар дэлхий” ХХК-аар хийлгэсэн. Үнэлгээнд тусгасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүйгээр үйлдвэрлэл явуулах, сөрөг нөлөөллийг боломжит хэмжээнд бууруулах талаар дараах арга хэмжээнүүдийг авч хяналт тавьж ажиллана.

### 9.1 Агаар

Агаарын бохирдлын хяналт шинжилгээ

Төсөл хэрэгжих талбайн агаарын бохирдлыг тодорхойлсон шинжилгээний үр дүн

Дээж авах цэг

- Ажлын байранд 2 цэг
- Цогцолборын талбайд 2 цэг

Хяналт шинжилгээ явуулах аргачлал

- Агаарын бохирдуулагч бодисын хүрэлцэх хэм хэмжээ MNS 5885:2008
- Агаарын бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэм хэмжээ MNS 4585:2007- Орон нутгийн мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, тухайн байгууллагаас гаргасан маягтаар тайланг гаргах

### 9.2 Хөрсөн орчин

- Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлын хяналт шинжилгээ
- Хөрсний механик бүрлэдхүүн

### 9.3 Усан орчин

Усны бохирдох нөлөөлөл болзошгүй тул дараах үзүүлэлтүүдээр хяналт шинжилгээ явуулна.

Үүнд:

- Мэдрэгдэхгүй чанар, физик үзүүлэлтүүд
- Хүчилтөрөгчийн үзүүлэлтүүд
- Хортой хүнд металлууд
- Нефтийн бүтээгдэхүүн
- Худгийн усны түвшин Дээж авах цэг
- Худгийн ус

Хяналт шинжилгээ явуулах хугацаа

- Жилд нэг удаа
- Усны шинжилгээнд дээж авах арга, химийн шинжилгээний стандартчилсан болон нийцүүлсэн аргууд MNS 3534-83
- Усны шинжилгээнд зориулж дээж авах MNS 3534-83
- Усны орчны чанарын үзүүлэлт MNS 4586-98



Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Бласт” ХХК-ийн Налайх салбарын  
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

